

**БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
“ТАЙЛАНГИЙН МАЯГТ”¹**

НЭГ. Товч танилцуулга²
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 79 дүгээр захирамжаар шинэчлэн батлагдсан “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц”-ийн дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль болон бусад хуулиар тусгайлан олгосон эрх хэмжээ, чиг үүргийг хариуцахын зэрэгцээ төрийн захиргааны байгууллагын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллалаг. Тус хөтөлбөрийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааны стратеги зорилтыг үндсэн 5 хэсэгт хуваан тодорхойлж, 5 хэлтэс, нийт 51 албан хаагчийн батлагдсан орон тоотой ажиллаж байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь үйл ажиллагааны эрхэм зорилго, стратегийн зорилтуудын хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх, удирдлага, менежментийг боловсронгуй болгох, төрийн өмчийн үр ашгийг дээшлүүлж, өгөөжийг нэмэгдүүлэх, төрийн өмчийн эзэмшилт, ашиглалтад хяналт шалгалт хийх, бүртгэлээр хяналт тавих, төрийн өмчийн бүртгэл, эзэмшилт, ашиглалт, зохицуулалтыг оновчтой зохион байгуулж, нэгдсэн дүн, статистик гаргах зэрэг хүрээнд хуулиар тусгайлан олгосон эрх хэмжээ, чиг үүргийг хэрэгжүүлж, төрийн өмчийн харилцааны асуудлаар Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайдыг холбогдох мэдээлэл, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангах үүрэг, хариуцлагыг хүлээдэг. Байгууллагын Ёс зүйн дэд хороог Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Ёс зүйн дэд хорооны ажиллаж журмын хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2024 оны А/20 дугаар тушаалаар дарга, гишүүд, нарийн бичгийн дарга гэсэн 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ёс зүйн дэд хорооны даргаар Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, нарийн бичгийн даргаа Хүний нөөцийн мэргэжилтэн ажиллаж байна. 2026 онд Ёс зүйн дэд хорооны ажиллаж журмын дагуу нийт албан хаагчдын дунд санал асуулга явуулан Дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулахаар төлөвлөж байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт³:
“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” (2024-2030)-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн албан хаагчдын манлайлал, хариуцлага, ил тод байдал, иргэдэд тэгш шударгаар үйлчилгээ үзүүлэх, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн

¹ Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

² Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

³ Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

асуудалд анхаарал хандуулах зэргээр нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан үйл ажиллагаа явуулахыг зорьж байна.

Албан хаагчдыг соён гэгээрүүлэх, хамтач нийтэч уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, шагнаж урамшуулах, төрийн дээд одон медаль болон салбарын шагналд тодорхойлох, зэрэг дэв ахиулах зэргээр албан хаагчдыг урамшуулан хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Байгууллагын сургалтын төлөвлөгөөг боловсруулахдаа ёс зүйн сургалтуудыг төлөвлөн, албан хаагчдын хэрэгцээ шаардлагад тулгуурлан ажлын байрны стрессээс урьдчилан сэргийлэх зорилгоор сэтгэцийн эрүүл мэндийн мэдлэг олгох сургалт болон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан.

Мөн сул орон тоон дээр шинээр томилогдож буй албан хаагчдыг сонгон шалгаруулах замаар болон бусад байгууллагаас шилжүүлэн томилох замаар сул орон тоог нөхөж, төрийн албаны манлайллыг ханган, ёс зүйн зөрчилгүй ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын Ёс зүйн дэд хороонд гомдол мэдээлэл бүртгэгдээгүй нь байгууллагын нийт албан хаагчид ёс зүйн манлайлан үзүүлэн ажиллаж байгаагийн илрэл гэж үзэж байна.

2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг цахимжуулж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг олон улсын жишигт хүргэх замаар салбарын үйл ажиллагааг манлайлан ажиллаж байна.

Мөн төрийн өмчит үйлдвэрийн газруудын Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгч, ашигт ажиллагааны түвшинг дээшлүүлэхэд байгууллагын нийт албан хаагчид манлайлж ажиллахыг зорьж байна.

Төрийн өмчийн захиран зарцуулалт, сонгон шалгаруулалтын шатанд ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон, байгууллагын соёлыг төлөвшүүлж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн, иргэд болон аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх үйлчилгээг чирэгдэлгүй, ёс зүйтэй хүргэх тал дээр анхааран ажилласаны үр дүнд тайлант хугацаанд ёс зүйн зөрчил бүртгэгдээгүй, байгууллагын ёс зүйн дэд хороонд шийдвэрлүүлэхээр иргэд болон аж ахуйн нэгж байгууллагаас аливаа гомдол санал ирээгүй болно.

Шилэн дансны хөтлөлт болон байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг цаг тухай бүрт нь шинэчлэн байршуулж, олон нийтийн хяналтад нээлттэй байлгах замаар авлига, хүнд суртлын эрсдлээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.

Иргэдээс ирүүлж буй өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд анхаарч, албан бичгийн шийдвэрлэлтэд тодорхой ахиц гарч байна. Олон нийттэй харилцах 1111 төвд бүртгэгдсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан талархалын хуудас манай байгууллагад ирсэн амжилттай ажилласан байна. 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар байгууллагын хэмжээнд нийт 135 өргөдөл гомдол бүртгэгдэж, 124 өргөдөл гомдлыг шийдвэрлэж, 11 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд явж байна.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

“Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлига, ашиг сонихролын зөрчлөөс ангид байх асуудлыг тусгасан. Мөн ёс зүйн дэд хорооны хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг 3 зорилт, 9 арга хэмжээний хүрээнд төлөвлөн батлуулж, хэрэгжүүлэн ажилласан байна.

Монгол Улсын Ёс зүйн хорооноос “Хүндэлье, энэрье” сарын аяныг 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлүүлсэнтэй холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Ёс зүйн дэд хорооноос уг аянд нэгдэж, аяны нээлтийн арга хэмжээг зохион байгуулсан. Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулж буй арга хэмжээний талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан, олон нийтэд сурталчилан ажиллаж байгаа бөгөөд орон нутгийн өмчийн газрууд мөн тус мэдээллийн хүрээнд

өөрсдийн байгууллага дээр Ёс зүйн хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэн, ёс зүйн аянд нэгдэж байгаа талаар мэдээлэл ирүүлсэн.

Тус аяны хүрээнд нийт албан хаагчдад ёс зүйн болон төрийн албаны стандарт, авилга, ашиг сонирхолын асуудал, бие болон сэтгэцийн эрүүл мэндийн талаарх сургалтуудыг зохион байгуулж, талархалын захидал бичих шуудангийн хайрцаг байршуулсан ба захидлуудыг 2025 оны тайлангийн хурал дээр уншиж танилцуулахаар төлөвлөж байна.

Мөн нийтээр амрах баярын өдрүүдэд амарсан нийт албан хаагчдыг нөхөн ажиллуулах тушаалын дагуу, хэлтсүүдийн хариуцан ажиллах хуваарийг батлаж, ажлын бус өдөр ажиллаж буй албан хаагчдаа идэвхжүүлэх зорилгоор Ёс зүйн дэд хорооноос хөгжөөнт болон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад хуулиудын асуулт бүхий дартсын тэмцээн зохион байгуулж, шалгарсан албан хаагчийг шагнаж урамшууллаа.

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга өөрийн мэдлэг боловсролоо дээшлүүлэх, сурсан мэдсэн зүйлсээ бусдад түгээн дэлгэрүүлэх зорилгоор Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо, ХҮЭК, Удирдлагын академи хамтран 2025 оны 11-р сард зохион байгуулсан "Ёс зүй ба хүний эрх" сэдэвт 2 өдрийн сургалт болон Ёс зүйн хорооноос Удирдлагын академитай хамтран Төрийн албан хаагчийн "Ёс зүйн сургагч багш" бэлтгэх хөтөлбөрийн гуравдугаар ээлжний сургалтад амжилттай хамрагдаж, төгссөн.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн дагуу бие даасан байдлаар, хараат бусаар ажиллаж, журмын дагуу урамшуулал авч ажиллаж ирсэн. 2025 оны сүүлийн хагас жилийн урамшуулал төсвийн тодотголын хүрээнд татагдсан тул гишүүдэд урамшуулал олгогдоогүй болно.

Гарсан үр дүн, ололт амжилт:

Бэрхшээл:

- Тайлант хугацаанд байгууллагын Ёс зүйн дэд хороонд ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл бүртгэгдээгүй нь нийт албан хаагчид ёс зүйн манлайлал үзүүлэн ажилласны илрэл юм.

- Албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр "Хүндэлье, энэрье" аяныг амжилттай зохион байгуулж, сургалт, уралдаан тэмцээн зэрэг олон талт арга хэмжээг хэрэгжүүлж, байгууллагын цахим хуудсаар дамжуулан нийтэд сурталчилсан.

- Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд ахиц гарч, Олон нийттэй харилцах 1111 төвд бүртгэгдсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтээр өндөр үнэлгээ авч, талархлын хуудас хүлээн авсан.

- Шилэн дансны хөтлөлт болон байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг цаг тухайд нь шинэчилж, ил тод, нээлттэй байдлыг хангаж, авлига, хүнд суртлын эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласан.

- Төсвийн тодотголтой холбоотойгоор 2025 оны сүүлийн хагас жилд Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшууллыг олгож чадаагүй нь тэдний идэвх, санаачилгад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

- Байгууллагын сургалтын зардал танагдаж байгаатай холбоотой төлбөрт сургалтуудыг авах боломжгүй болсон.

Санал:

- Дэд хорооны гишүүдийн ажлыг идэвхжүүлэх, тогтвортой ажиллагааг хангах үүднээс урамшууллын асуудлыг төсөвт тусган шийдвэрлэх.
- Албан хаагчдын ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх сургалт, арга хэмжээг төлөвлөгөөний дагуу тогтмолжуулж, үр дүнг тооцож ажиллах.

Шалгах хэсэг:

- ☐ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

ДАРГА
/Албан тушаал/

/Гарын үсэг/

Б.ЦЭНГЭЛ
/Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

/Албан тушаал/

/Гарын үсэг/

Н.ГАНБОЛД
/Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН
/Албан тушаал/

/Гарын үсэг/

Н.ДАГИЙМАА
/Гарын үсгийн тайлал/

Огноо: 2026 оны 01 сарын 05